



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР



УСНЫ ҮНЭ, НӨӨЦИЙН ТАЛААРХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2025 он



ТАЙЛАН ХЯНАСАН:

Б.Батцэцэг, ЗГХХГ-ын дарга

Н.Баярмаа, ЗГХХГ-ын Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга

Б.Аз, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга

С.Рэгзэн, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн референт

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Х.Оюунчимэг, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, судалгааны багийн ахлагч

Н.Лхам, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн референт, судалгааны багийн гишүүн

М.Анхзаяа, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн

Т.Энхзаяа, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, судалгааны багийн гишүүн

Ц.Нямбуу, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн Эрсдэлийн шинжилгээ хариуцсан ажилтан, судалгааны багийн гишүүн

Э.Гантуяа, ЗГХХГ-ын Тандалт судалгаа бодлого, төлөвлөлтийн газрын эдийн засгийн бүтээмж хариуцсан ажилтан, судалгааны багийн гишүүн

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

Засгийн газрын II байрны Г корпус, С.Данзангийн гудамж, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар, Монгол Улс

Холбоо барих: (976-51) 26 20 46

Цахим шуудан: info@ags.gov.mn

Веб сайт: www.ags.gov.mn



АГУУЛГА:

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСАЛТ

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Судалгааны аргачлал

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УСНЫ САЛБАРЫН ТОГТОЛЦОО

- 1.1. Усны салбарын эрх зүйн орчин
- 1.2. Усны салбарын тогтолцоо, чиг үүргийн хуваарилалт
- 1.3. Бүлгийн дүгнэлт

ХОЁРДУГААР БҮЛЭГ: УСНЫ ҮНЭ ТАРИФ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- 2.1. Усны үнэ тогтоох үндэслэл
- 2.2. Усны үнэ, тариф тооцох олон улсын загвар
- 2.3. МУ-д хэрэглэгдэж буй цэвэр, бохир усны үнэ, тариф тооцох аргачлал
- 2.4. Усны нөөц ашигласны төлбөр
- 2.5. Ус бохирдуулсны төлбөр
- 2.6. Бүлгийн дүгнэлт

ГУРАВДУГААР БҮЛЭГ: УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

- 3.1 Гадаргын усны нөөцийн байдал
- 3.2 Газар доорх усны нөөцийн байдал
- 3.3 Усны нөөцийн ашиглалт
- 3.4 Олон улсын туршлага
- 3.5 Бүлгийн дүгнэлт

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

САНАЛ

ХАВСРАЛТ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МАА	Мал аж ахуй
МУ	Монгол Улс
НАА	Нийтийн аж ахуй
НААҮБ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллага
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
СГ	Сав газар
СГЗ	Сав газрын захиргаа
СГБ	Сав газрын байгууллагууд
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УННМ	Усны нөөцийн нэгдсэн менежмент
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УИХ	Улсын Их хурал
УТХОХ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮҮЗ	Усны үндэсний зөвлөл
УХАТ	Ус хангамж, ариутгах татуурга
УХАТАҮ	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ
УЦБ	Урьдчилан цэвэрлэх байгууламж
ҮАЗ	Үйл ажиллагааны зардал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХТХН	Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр
ХАА	Хөдөө аж ахуй
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХСУХАТАҮЗХ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Усны үнэ, тариф тооцох аргачлал.....	17
Хүснэгт 2. Тарифын тогтолцооны харьцуулсан үнэлгээ	17
Хүснэгт 3. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф /нөат-гүй/.....	20
Хүснэгт 4. УБ хотын УСУГ-ын 2020-2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт:	21
Хүснэгт 5. УБ хотын УСУГ-ын эдийн засгийн үзүүлэлтийг цэвэр, бохир усны ангиллаар:	22
Хүснэгт 6. Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифын доод хязгаар /хувиар/.....	23
Хүснэгт 7. Хөдөө орон нутаг дахь цэвэр, бохир усны үйлчилгээний тариф.....	23
Хүснэгт 8: Цэвэр, бохир усны үнэ тарифын өөрчлөлт, Орон нутгаар	24
Хүснэгт 9. Усны нийт олборлолт, усны нөөцийн төрлөөр, 2023 он	32
Хүснэгт 10. Усны нийт олборлолт, зориулалтаар.....	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улсын хэмжээнд усны менежментэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд.....	12
Зураг 2. Улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт	14



УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд усны нөөцийн хомсдол, ундны усны хүртээмж, чанарын асуудал нь тогтвортой хөгжлийн голлох шалгуур үзүүлэлтүүдийн нэг болж, улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогод стратегийн түвшинд авч үзэх зайлшгүй шаардлагатай асуудал болоод байна. Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн эрэлт нэмэгдсэн нь усны нөөцөд үзүүлэх дарамтыг улам бүр нэмэгдүүлж, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлого, менежментийг шинжлэх ухааны үндэстэйгээр хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Монгол Улс нь уур амьсгалын эрс тэс нөхцөлтэй, хур тунадасны хэмжээ бага, усны нөөцийн газарзүйн хуваарилалт жигд бус, гадаргын усны урсац улирлын шинжтэй, ууршлын нөлөөнд ихээхэн өртдөг онцлогтой орон юм. Ийм нөхцөлд усны нөөц хязгаарлагдмал бөгөөд байгаль, уур амьсгалын хүчин зүйлээс гадна хүний үйл ажиллагааны нөлөөгөөр усны чанар, хүртээмжид сөрөг өөрчлөлт гарах эрсдэл нэмэгдэж байна.

Манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, хот суурин газрын тэлэлт, уул уурхай болон үйлдвэрлэлийн салбарын усны хэрэгцээ нэмэгдсэн нь усны нөөцийн тогтвортой ашиглалт, хамгаалалтыг нэн тэргүүний асуудал болж байна. Иймээс усны салбарын тогтолцоо, усны үнэ тарифын бодлого, усны нөөцийн бодит нөхцөл байдлыг цогцоор нь судлах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Түүнчлэн “Алсын хараа–2050”, “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын хүрээнд усны нөөцийн аюулгүй байдлыг хангах, усны хэрэглээг хэмнэлттэй, үр ашигтай болгох зорилтууд дэвшүүлсэн нь усны нөөц, үнийн бодлогын өнөөгийн байдлыг судлан үнэлэх үндэслэл болж байна.

Судалгааны аргачлал

Зорилго, зорилт:

Энэ судалгааны зорилго нь Монгол Улсын усны нөөц, хэрэглээний талаарх мэдээллийг шинжилж, өөрчлөлтийн хандлагыг тодорхойлох, усны үнэ тариф, бодлого, удирдлагын тогтолцоонд үнэлгээ өгөх, усны үнэ тарифын олон улсын туршлагатай харьцуулан манай улсын нөхцөлд тохиромжтой бодлогын санал боловсруулахад оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна:

- Монгол Улсын усны салбарын бүтэц тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг судлах;
- Усны үнэ, тариф тогтоож буй байдал, анхаарах асуудлыг судлах;
- Монгол Улсын усны нөөцийн хэмжээ, ашиглалтын бодит нөхцөлийг судлах;
- Олон улсын туршлага, сайн жишиг судалж, Монгол Улсын нөхцөлд



тохиромжтой санал боловсруулах.

Судалгааны арга зүй:

Судалгаанд хоёрдогч мэдээллийн эх сурвалж, үүнд, нийтэд нээлттэй мэдээлэл, албан ёсны статистик, бодлогын баримт бичиг, судалгааны тайлан, өгүүлэл зэргийг ашигласан. Судалгааг дараах үе шатаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Мэдээлэл цуглуулах

Судалгаанд ашигласан мэдээллийг дараах эх сурвалжаас цуглуулж ашиглалаа. Үүнд:

- Усны салбарын тогтолцоо, эрх зүйн орчин, бодлогын баримт бичигтэй холбоотой мэдээллийг байгууллагын болон төрийн мэдээллийн цахим хуудаснаас;
- Цэвэр, бохир усны батлагдсан үнэ тариф, усны нөөцийн мэдээллийг холбогдох байгууллагуудаас албан бичгээр;
- Усны үнэ тарифын тогтолцоо, олон улсын жишигтэй харьцуулсан судалгааны өгөгдлийг нээлттэй эх сурвалж, тайлангаас;
- Усны нөөцийн хэмжээ, тархалт, үнийн талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагын тайлан, судалгаанаас.

2. Мэдээлэл боловсруулах, шинжлэх

- Цуглуулсан мэдээллийг ангилж, бүлэглэх замаар судалгааны зорилтуудтай уялдуулан системчилсэн;
- Аймаг, нийслэлийн цэвэр болон бохир усны 2020-2024 оны үнэ тарифыг харьцуулсан шинжилгээний арга зүйг хэрэглэсэн;
- Усны үнэ тариф, олон улсын туршлагыг судлахдаа харьцуулсан шинжилгээний арга зүйг хэрэглэсэн;

3. Дүгнэлт, зөвлөмж боловсруулах

- Нэгтгэн боловсруулсан мэдээлэл, дүн шинжилгээг гадаад улс орон, олон улсын байгууллагын туршлагатай уялдуулан санал, зөвлөмжийг боловсруулсан.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УСНЫ АСУУДЛЫГ ХАРИУЦСАН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

1.1. Усны салбарын эрх зүйн орчин

Усны нөөцийн тогтвортой ашиглалт, хамгаалалт нь дэлхий дахины хөгжлийн салшгүй хэсэг бөгөөд олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалттай нягт холбоотой. Энэхүү бүлэгт усны салбарын эрх зүйн зохицуулалт, байгууллагын бүтэц, чиг үүргийн талаарх мэдээллийг судлан, нэгтгэн боловсрууллаа.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”-д тусгагдсан “Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах” зорилтын хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улс эрх зүй, бодлогын орчноо боловсронгуй болгоход анхаарч байна.

Хууль:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.” гэж заасан.

Усны тухай хуулиар усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн.” 4.3 дахь хэсэгт “Усыг ашиглах боломжит нөөцийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим баримтална.” гэж заасны дагуу төрөөс усны нөөцийг ашиглахдаа үр ашигтай, хэмнэлттэй байх менежмент, бодлого зохицуулалтыг хангаж ажиллаж байна. Мөн тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах”, хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.7 дахь заалтад заасны дагуу “Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны экологи-эдийн засгийн үнэлгээ, усны үнэ, тариф тогтоох чиглэлээр судалгаа хийх аргачлал, зааврыг боловсруулах, усны нөөцөд учруулсан хохирлыг тооцох” тухай тусгасан байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна гэж заасан. Мөн тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Төлбөрийн хэмжээг хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээнд үндэслэн бүс нутгийн хөгжлийн онцлогийг харгалзан дараах хязгаарт багтаан Засгийн газар тогтоож болно”, хуулийн 7.3 дахь хэсэгт “Төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50



хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж, цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна” гэж тус тус заасан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна”, хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт усны нөөц ашигласны төлбөрийн дараах үзүүлэлтээр тооцохоор тусгасан байна. Үүнд:

- 10.1.1. усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс;
- 10.1.2. хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр;
- 10.1.3. уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Усны нөөц, ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тооцох”, 15.2 дэх хэсэгт “Рашаан ашигласны төлбөрийн хэмжээг тооцох тухай”, 15.3 дахь хэсэгт “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг Засгийн газар, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг бүс нутгийн хөгжлийн онцлогийг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тус тус тогтоохоор заасан. Хуулийн 20 дугаар зүйлд “усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх” зохицуулалтыг тусгасан байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байна” гэж, хуулийн 10.1.1 дэх хэсэгт “Зохицуулах хороо нь цэвэр, бохир усны үйлчилгээний тарифын бүтцийг тодорхойлох, тариф тогтоох аргачлал, төлбөр тооцох журам, цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, цэвэр усны мөрдөж байгаа үнэ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийн үндэслэлд олон нийтийн хяналт тавина” гэж тус тус заасан байна.



Бодлогын баримт бичиг:

Төрөөс усны нөөцийг хамгаалах, ундны усны хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр олон удаагийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд усны нөөцийн хомсдолоос сэргийлэх, усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгох чиглэлээр дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- Хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлэх;
- Усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, нөөцийг хамгаалах, өсгөх ажлыг санхүүжүүлэх механизмыг тодорхой болгох;
- Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн усны эрэл, хайгуулын зардлыг эргэн төлүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийх;
- Газар доорх усны нөөцийг шинэчлэн тогтоох усны эрэл, гидрогеологийн зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийж, нөөцийг бүртгэлжүүлж, мэдээллийн сан, хяналт-шинжилгээний сүлжээ, судалгаа шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлэх;
- Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах;
- Цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаалах;
- Усны сав газрын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, тухайн сав газрын хэмжээнд экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглах боломжтой гадаргын болон газрын доорх усны нөөцийг тогтоож, ашиглалтыг тогтоосон хэмжээнд нь хатуу барих;
- Аль нэг ашиглагчид давуу эрх олгохгүй байх эрх зүйн зохицуулалт бий болгох;
- Гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс томоохон гол, мөрөнд урсцын тохируулга хийж, бороо, цас, мөсний усыг хуримтлуулж, нөөцлөх усан санг ууршил багатай, эрчим хүчний нөөц ихтэй бүс нутагт байгуулж, говь, тал хээрийн ууршил ихтэй бүсэд усыг нөөцлөх;
- Дамжуулах далд систем барьж байгуулах, усны хэмнэлттэй хэрэглээ, технологийг нэвтрүүлэх;
- Ус, эрчим хүчний ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, газар тариалангийн усалгаанд газрын доорх усыг ашиглах болон хүнсний бус үйлдвэрлэлийн салбарт ундны цэвэр усыг ашиглах явдлыг хязгаарлах;
- Хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх;
- Цэвэршүүлсэн хаягдал ус болон саарал усыг дахин ашиглахыг бодлогоор дэмжих зэрэг болно.



Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого”-д 6.3.1-т “Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.” гэж, 6.3.2-т “Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өсгөх зарчимд суурилж тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.” гэж тусгасан байна. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэн зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг тодорхойлсон. Үүнд, I үе шатанд 2021-2030 онд Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах, усны нөөцийн үнэ тарифт шатлан өсгөх зарчим тогтоож, усны хэрэглээг төлбөртэй болгон хэмнэлт, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах чиглэлээр тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээх талаар тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.7, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 2.2.4.15-д “Туул усан цогцолбор төсөл”-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлнэ.” гэж тусгасан. Мөн усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ гэсэн байна.

Усны нөөцийн хомсдолоос сэргийлэх, усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, усны хэмнэлттэй хэрэглээ, технологийг нэвтрүүлэх, усны ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуй, хүнсний бус үйлдвэрлэлийн салбарт ундны цэвэр усыг ашиглах явдлыг хязгаарлах, хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэршүүлэх, цэвэршүүлсэн хаягдал ус болон саарал усыг дахин ашиглах асуудал нь нэн тэргүүний зорилго болж Монгол Улсын хөгжлийн бодлогын бичиг баримтад тодорхой тусгагдсан байна.

1.2. Усны салбарын чиг үүргийн хуваарилалт

Монгол Улсын усны салбар нь хууль тогтоох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын уялдаа холбоонд тулгуурласан дараах тогтолцоотой байна.

Монгол Улсын Их Хурал нь усны асуудлаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийг соёрхон батлахаас гадна улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт усны асуудлыг тусгах, хэрэгжилтэд хяналт тавих, ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.



Засгийн газар болон Ерөнхий сайд нь батлагдсан хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, яамд хоорондын уялдаа холбоог ханган ажилладаг.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) нь усны нэгдсэн бодлого боловсруулах, усны нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, хамгаалах, менежментийг сайжруулах зэрэг ус, байгаль орчны асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага юм. Тус яам нь усны талаар төрөөс баримтлах бодлого болон Усны нөөцийн нэгдсэн менежментийн (УННМ) төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг. БОУАӨЯ-ны харьяанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Усны газар болон Цаг уур, орчны шинжилгээний газар үйл ажиллагаа явуулдаг.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Усны газар нь ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, усны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, усны нөөц болон ашиглалтын талаарх мэдээллийг бүртгэх, усны нөөцөд учирсан хохирлыг тооцох, ус ашиглалтад хяналт тавих, усны мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус агентлаг нь иргэдийн ахуйн усны хэрэглээтэй шууд холбоотой нарийвчилсан үйлчилгээ эрхэлдэггүй бөгөөд ихэвчлэн байгалийн усны нөөцийн ашиглалт, бүртгэл, хяналтын чиглэлээр ажилладаг.

Монгол Улсын нутаг дэвсгэр нь 29 усны сав газарт хуваагддаг бөгөөд тэдгээрийг 21 сав газрын захиргаа хариуцан ажилладаг. Сав газрын захиргааны үндсэн чиг үүрэг нь тухайн сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, уг төлөвлөгөөг орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулахад оршино. Сав газрын талуудын оролцооны зөвлөл нь оролцогч талуудын оролцоог хангах, шийдвэр гаргалтад оролцуулах, хяналт-шинжилгээ хийх, сав газрын УННМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бөгөөд тус зөвлөлд төрийн байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөл багтдаг.

Зарим яамны чиг үүрэг нь өөр өөр ус ашиглагчид зориулсан ус хангамжийг зохицуулахад чиглэсэн байна.Тухайлбал:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрүүл мэндийн яам болон бусад салбарын яамд усны нөөц ашиглалт, усалгааны бодлого, ундны усны эрүүл ахуй, үйлдвэрлэлийн ус хэрэглээ зэрэг салбар дундын асуудалд оролцон ажилладаг.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн зориулалттай ус хангамжийн нөөц, бэлчээрийн хамгаалалт, нөхөн сэргээлт, менежментийг хариуцдаг. Мөн гадаргын усыг ашиглан усалгаатай тариалангийн зориулалтаар жижиг усан сан, суваг шуудуу байгуулах, мал аж ахуйн зориулалттай усан хангамжийг нэмэгдүүлэх, гүний худаг, цооногийн тоог өсгөх зэрэг арга хэмжээг салбарын бодлого, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлдэг.

Уул уурхайн салбарын усны хэрэглээ, усны эх үүсвэрийн хайгуул, геологийн судалгаатай холбоотой чиг үүргийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хэрэгжүүлдэг.



Газрын доорх усны шинэ уст давхарга илэрсэн тохиолдолд холбогдох мэдээллийг бүртгэн мэдээлдэг.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээтэй холбоотой бодлого, төлөвлөлт, хөгжлийн асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам хариуцдаг.

Аймаг, нийслэлийн түвшинд Засаг дарга нь төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх удирдлагын чиг үүргийг гүйцэтгэж, тухайн нутаг дэвсгэрийн ус, байгаль орчны асуудлыг зохион байгуулдаг. Байгаль орчны газар, ус цаг уурын байгууллага болон бусад холбогдох байгууллага нь мэргэжлийн хяналт болон хэрэгжилтийг ханган ажилладаг. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь орон нутгийн бодлого, төсөв, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.


Сум, дүүргийн түвшинд Засаг даргын Тамгын газар бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, байгаль орчны мэргэжилтэн болон холбогдох байгууллагууд усны ашиглалт, хамгаалалт, хяналтын ажлыг хэрэгжүүлдэг. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь орон нутгийн хөгжлийн асуудал болон байгаль орчны бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, шийдвэр гаргах оролцоог хангадаг.

Баг, хорооны түвшинд Засаг дарга болон Иргэдийн нийтийн хурал нь иргэдийн оролцоог хангаж, байгаль орчны хамгаалалт, ус ашиглалтын зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр ажилладаг.

Иргэдийн ундны болон ахуйн хэрэглээний зориулалтаар усыг хэрэглэхтэй холбогдсон бодлого зохицуулалтыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд зааснаар Засгийн газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах хороо, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд хэрэгжүүлж байна.

[Зураг 1. Улсын хэмжээнд усны менежментэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд¹](#)

¹ Эх сурвалж: (ЭЗХАХБ, Азийн усны зөвлөл, 2025)



Ийнхүү Монгол Улсын усны салбар нь олон түвшний, олон байгууллагын оролцоотой, салбар дундын уялдаа шаардсан зохион байгуулалтын тогтолцоотой бөгөөд бодлого, зохицуулалт, хэрэгжилтийн уялдаа холбоог хангах нь усны нөөцийн тогтвортой менежментийн үндэс болдог.

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ эрхлэгч төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ (УХАТАУ)-ний тогтолцоо нь бодлого боловсруулах, зохицуулах, гүйцэтгэх, хяналт тавих болон хэрэглэгчийн түвшний харилцааг хамарсан бүтэцтэй байна.

Энэхүү судалгааны хүрээнд айл өрх, албан байгууллагын усны үнэ тарифын талаар тандалт судалгаа хийж буй тул уг үйлчилгээтэй холбоотой байгууллагуудын бүтэц, чиг үүргийг авч үзлээ.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь усны нөөцийн бодлого, сав газрын менежмент, байгаль орчны хяналт, усны хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус яамны харьяанд Усны газар, сав газрын захиргаа зэрэг байгууллагууд ажиллаж, усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулдаг.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн төлөвлөлт, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт, салбарын хөгжлийн бодлогыг хариуцдаг.




Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулах хороо нь тариф тогтоох, тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ингэснээр үйлчилгээний чанар, санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж байна.

Нийслэлийн хэмжээнд Улаанбаатар хотын захиргаа бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, Ус сувгийн удирдах газар нь ус олборлох, цэвэрлэх, түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Мөн Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний удирдах газар болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хэрэглэгчдэд ус түгээх, гэрээ байгуулах, төлбөр хураах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Хотжилтын түвшнээс хамааран дүүргийн засаг захиргаа ус түгээлт, бохир ус татах үйлчилгээ, ус ашигласны төлбөртэй холбоотой зохион байгуулалтын үүргийг хэрэгжүүлэх боломжтой. Харин хөдөө, орон нутагт аймаг ус хангамжийн үйлчилгээг бүхэлд нь хариуцах зохион байгуулалттай байдаг.

Зураг 2. Улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт²



Ийнхүү зураг 2-т үзүүлсэн бүтэц нь усны нөөцийн бодлого, дэд бүтцийн төлөвлөлт, тарифын зохицуулалт, үйлчилгээний гүйцэтгэл болон хэрэглэгчийн харилцааг уялдуулсан олон талт тогтолцоог илэрхийлж байна. Энэхүү зохион байгуулалт нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тогтвортой байдал,

² Эх сурвалж: OECD/AWC (2025), Монгол Улсын усны эрэлтийн менежмент: Усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/ccb61f9b-mn>.



санхүүгийн зохицуулалт, хэрэглэгчийн хүртээмжийг хангахад чиглэдэг байна.

1.3. Бүлгийн дүгнэлт

Усны нөөцийн удирдлагын тогтолцоо нь олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, чиг үүргийн зохистой хуваарилалт, байгууллага хоорондын зохицуулалт, хамтын ажиллагаанд суурилсан цогц, шаталсан удирдлагын механизм болно. Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль, тогтоомжоор усны нөөцийг төрийн болон нийтийн өмч, стратегийн үнэт баялаг гэж тодорхойлж, ашиглалт, хамгаалалт, төлбөрийн тогтолцоог нарийвчлан зохицуулсан байдаг. Усны тухай хуулиар усыг үр ашигтай, хэмнэлттэй ашиглах зарчим, хяналт-шинжилгээний нэгдсэн тогтолцоог бий болгох төрийн үүргийг тодорхойлж, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд бохирдуулагч этгээдэд төлбөр ногдуулах, түүнийг усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зохицуулалт тусгагдсан байна. Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг хэрэглээний зориулалт, хэмжээнээс хамааруулан тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

“Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт усны нөөцийг хамгаалах, хэмнэлттэй ашиглах, дахин ашиглалтыг дэмжих, сав газрын менежментийг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан. Усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, шаталсан тарифын тогтолцоо нэвтрүүлэх, гадаргын усыг хуримтлуулах, хаягдал усыг дахин ашиглах зэрэг арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын усны салбарын бүтэц, чиг үүрэг нь хууль тогтоох, бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах, хяналт-шинжилгээ хийх болон үйлчилгээ үзүүлэх гэсэн олон түвшний, олон оролцогч бүхий тогтолцоонд суурилж байна.

Салбарын бодлогын түвшинд УИХ, Засгийн газар, холбогдох яамд усны нөөцийн нэгдсэн менежмент, усны аюулгүй байдал, хэмнэлттэй ашиглах, хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж, Усны газар, сав газрын захиргаа, орон нутгийн байгууллагууд усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, төлөвлөлт, хяналт, мониторингийг хариуцан ажиллаж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг Зохицуулах зөвлөл, орон нутгийн засаг захиргаа, төрийн өмчит болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын оролцоонд тулгуурлан хэрэглэгчид хүргэж байна.

Сав газрын захиргаа, оролцооны зөвлөлүүд орон нутгийн түвшинд усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлдэг. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг ХББОСЯ, ХСУХАТАҮЭХ, орон нутгийн захиргаа болон төрийн өмчит, хувийн байгууллагуудын оролцоотой, салбар дундын ажиллагааны хүрээнд хэрэглэгчдэд хүргэж байна. зохицуулалттай юм.

Нэгтгэн дүгнэхэд, Монгол Улсын усны салбарын эрх зүйн бодлогын орчин,



асуудлыг хариуцсан бүтэц, тогтолцоо бүрдсэн бөгөөд энэ нь усны нөөцийг хамгаалах, хэмнэлттэй ашиглах, урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах үндсэн нөхцөл болох юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: УСНЫ ҮНЭ ТАРИФ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхийн олон улс оронд усны үнэ тарифыг тогтоох бодлого нь зөвхөн үйлчилгээний өртгийг нөхөхөөс гадна усны хомсдолыг бууруулах, тогтвортой хэрэглээг дэмжих стратегийн арга хэрэгсэл болж хөгжсөн байна.

Усны үнэ тарифын өнөөгийн байдал, тогтолцооны онцлог, тариф тогтоох аргачлал, хэрэгжилтийн үр нөлөө, олон улсын туршлагыг харьцуулан судлах нь усны салбарын бодлогын шинэчлэлд чухал ач холбогдолтой юм. Иймд Монгол Улсын усны үнэ тарифын тогтолцоо, тарифын бүтэц аргачлал, аймаг, нийслэлийн цэвэр болон бохир усны үнэ тарифыг харьцуулалтын судалгааны үр дүн, тулгамдаж буй асуудлыг энэ бүлэгт багтаасан болно.

2.1. Усны үнэ тогтоох хэрэгцээ, шаардлага

Манай улсын усны хэрэглээний дийлэнх хэсэг буюу 80-90 хувийн доорх усны нөөцөөс хангаж байна. Газрын доорх усны нөхөн сэргэх хугацаа урт, байгаль экологийн хувьд маш эмзэг учраас газрын доорх усны хэрэглээг зохистой болгох шаардлага үүсээд байгаа тул усны үнэ, тарифыг оновчтой тогтоох нь чухал юм.

Усны үнэ, тариф нь зөвхөн үйл ажиллагааны зардлыг нөхөхөөс гадна ус ашиглалтыг оновчтой төлөвлөх, хязгаарлагдмал нөөцийг зөв хуваарилах, мөн орлого багатай иргэдийн эрх ашгийг хамгаалах механизмыг агуулсан бодлогын арга хэрэгсэл байх ёстой.

Ус нь хүний өдөр тутмын амьдралын зайлшгүй хэрэгцээ, эрүүл мэндтэй шууд хамааралтай тул олон нийт үүнийг үндсэн эрх хэмээн үзэж, усаа зөвхөн үйлчилгээний зардлыг багтаасан, бодит өртгөөс хэт доогуур үнээр авч байгаа нь усны үнэ цэнийг бууруулах, зүй зохисгүй хэрэглээг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна. Энэ ойлголт нь усны үнийг зохиомлоор доогуур барих, төрөөс татаас олгох бодлогыг түлхүү хэрэгжүүлэхэд хүргэдэг ч эцсийн дүндээ энэ зардлыг татвар төлөгчид, аж ахуйн нэгжүүд эсвэл зээл, тусламжаар нөхөхөөс өөр аргагүйд хүргэж байна.

Иймд усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нь нэн чухал байна. Тодруулбал, усны салбар дахь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, байгууллагуудын чадавх, санхүүгийн бие даасан байдал, засаглалыг бэхжүүлэх шаардлагатай. Ингэснээр хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэж, төрийн санхүүжилтийн оновчтой хуваарилалт, салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой болно.

2.2. Усны үнэ, тариф тооцох олон улсын загвар



Олон улсад усны үнэ, тариф тооцох “нэг талт тариф” болон “хоёр талт тариф” гэсэн 2 үндсэн загвар байна.³

Хүснэгт 1. Усны үнэ, тариф тооцох аргачлал

НЭГ ТАЛТ ТАРИФ	
1	А. Тогтмол төлбөр–сарын усны төлбөр усны хэрэглээнээс хамаарахгүй байх тогтмол төлбөр.
	Б. Усны хэмжээнээс хамаарах төлбөр I.Ус ашиглалтын хэмжээнээс хамаарсан тариф II.Блок тариф–ус ашиглалтын тодорхой хэмжээний дотор нэгжийн үнэ нь тогтмол байж байгаад түүнээс хэтэрсэн тохиолдолд өөрчлөгддөг тариф <ul style="list-style-type: none"> • Өсөх эрэмбийн блок тариф • Буурах эрэмбийн блок тариф
	III.Шугаман өсөх тариф–ус ашиглалтын хэмжээний өсөлттэй шууд хамааралтайгаар нэгжийн үнэ өсөх тариф
ХОЁР ТАЛТ ТАРИФ	
2	Тогтмол төлбөр+Ус ашигласан хэмжээнээс хамаарах төлбөр

Нэг талт тариф хэрэглэж байгаа үед хэт бага усны үнэ тогтоох нь нийлүүлэлтийн нийт зардлыг нөхөж чадахгүйд хүрдэг бол хоёр талт тариф хэрэглэж байгаа үед тоолуурт төлбөрийн үнийн үндсэн зарчмыг хөндөхгүйгээр тогтмол төлбөрөөр шаардлагатай орлогыг олж болно.

Хүснэгт 2. Тарифын тогтолцооны харьцуулсан үнэлгээ ⁴

Тарифын бүтэц	Зардал нөхөх	Эдийн засгийн үр ашиг	Тэгш байдал	Худалдан авах чадамж
Тогтмол төлбөр	Боломжийн	Муу	Муу	Боломжийн
Тогтмол тоолуурт төлбөр	Сайн	Сайн	Сайн	Сайн
Өсөх блок тариф	Сайн	Муу	Муу	Муу
Буурах блок тариф	Сайн	Муу	Муу	Муу

Дээрх загвараас үзэхэд усны үнэ, тарифын хэмжээг тогтоохдоо зардлаа нөхөх зарчим, эдийн засгийн үр ашиг, худалдан авах чадамж, тэгш байдал /хэрэглэгчдэд хүрэх хүртээмж/ зэргийг хангах шаардлагатай.

³ Усны үнэ тариф, төлбөрийг тооцох гарын авлага УБ хот. 2012 он. 5 тал

⁴ Усны үнэ тариф, төлбөрийг тогтоох гарын авлага. УБ хот. 2012 он. 11 тал



ШИГТГЭЭ. Усны үнэ, тариф тооцох олон улсын загвар- Австралийн жишээ¹

Австрали улс усны хомсдолтой нөхцөлд усны нөөцийг эдийн засгийн хөшүүргээр дамжуулан үр ашигтай, тогтвортой ашиглах бодлогыг эртнээс хэрэгжүүлж ирсэн улс орнуудын нэг юм. Тус улсын усны үнэ, тарифын бодлого нь “ус бол эдийн засгийн баялаг” гэсэн суурь зарчимд тулгуурлаж, ус ашиглалтын бодит өртгийг хэрэглэгчдэд ойлгуулах, хэт ашиглалтыг хязгаарлах, байгаль орчны хамгаалалтыг санхүүжүүлэх зорилготой.

Австралийн ихэнх муж, нутаг дэвсгэрт усны үнэ тогтоохдоо бүрэн өртөг нөхөх (full cost recovery) зарчмыг баримталдаг. Үүнд ус олборлох, дамжуулах, цэвэршүүлэх, түгээх, бохир ус цуглуулах, цэвэрлэх зардлаас гадна байгаль орчны болон нөөцийн өртгийг үе шаттайгаар тарифт тусгаж ирсэн. Мөн усны хэрэглээг хэмнэх зорилгоор хэрэглээний хэмжээнээс хамаарсан шаталсан тариф (inclining block tariff)-ыг өргөн хэрэглэдэг нь ахуйн болон хөдөө аж ахуйн салбарт усны үр ашигтай хэрэглээг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

2.3. Монгол улсад хэрэглэгдэж байгаа цэвэр, бохир усны үнэ, тариф тооцох аргачлал

Цэвэр, бохир усны тариф, төлбөр тооцоолох аргачлалыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулах хорооны 2018 оны 11 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2018, 2020, 2021, 2025 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Тариф гэдэг нь 1 литр усны жишиг үнэ юм.

Аргачлалын дагуу

- Тариф тооцоход ашиглах хэрэглэгчдэд нийлүүлэх цэвэр ус, хүлээн авах бохир усны хэмжээ
- Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ
- Суурь үнэ тооцох
- Хэрэглэгч ийн ангилал, зардлын хуваарилалт
- Усны хэрэглээнээс хамаарах тариф
- Усны хэрэглээнээс хамаарах тариф
- Усны үйлчилгээний үнэ, тарифыг индексжүүлэх гэсэн тооцоог хийдэг

Цэвэр, бохир усны тариф, төлбөр тооцоолох аргачлал нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үзүүлэх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөрийг холбогдох бүс бүрээр тодорхойлох зорилготой.



Хэрэглэгчийн ангилал, зардлын хуваарилалт ⁵

Цэвэр, бохир усны тариф, төлбөр тооцоолоход ус хэрэглэгч, ашиглагчдыг дараах ангилалд хамруулан авч үзнэ. Үүнд:

А.Өрхийн (Усны тоолуур, тоолуургүй)

В. Үйлдвэр, үйлчилгээ, ААН, байгууллага

а. Доор дурдсанаас бусад үйлдвэр, үйлчилгээ, ААН, байгууллага

б. Төрийн сектор-Байгууллагууд

с. Спирт, архи, пиво, ундаа, жүүс, ус, талх нарийн боовны үйлдвэр, мах сүү боловсруулах үйлдвэр, эмнэлэг

д. Ноос, ноолуур, арьс шир, автомашин угаалга

Дээр дурдсанаас бусад үйлдвэр, үйлчилгээ, ААН, байгууллага????

Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ

Аргачлал нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тасралтгүй үйл ажиллагаа, найдвартай байдал, хэрэглэгчийн чанарын үүднээс “шаардлагатай орлого”-ын тооцоололд суурилдаг. Тиймээс ашиглалт, засвар үйлчилгээ нь сүүлийн 3 жилийн бодит гүйцэтгэл болон ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурилдаг⁶.

Шаардлагатай орлого = Үйл ажиллагааны зардал+Элэгдлийн зардал+
Хөрөнгө оруулалтын өгөөж

Тариф, төлбөр тооцоолоход шаардлагатай борлуулалтын орлого

Тариф, төлбөр тооцоолоход шаардлагатай борлуулалтын орлого =
Борлуулалтын орлогын шаардлагатай дүн- Суурь хураамжийн орлого +Гэр хорооллын оршин суугчдад нийлүүлдэг зөөврийн усны алдагдал

Тогтмол тариф

Суурь үнэ буюу эсхүл тогтмол тариф нь төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээтэй холбогдсон хэрэглэгчдэд 24 цагийн тасралтгүй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээний байнгын хүртээмжтэй байх

⁵ “Монгол Улсын усны эрэлтийн менежмент” усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлангийн 118 тал

⁶ “Монгол Улсын усны эрэлтийн менежмент” усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлангийн 118 тал.



нөхцөлөөр хангах зорилготой.

Унд, ахуйн зориулалтаар ус хэрэглэгчид: Суурь үнэ = Тогтмол зардал/(12*хэрэглэгчдийн тоо) (төг/сар)

Бусад хэрэглэгч, ашиглагч: Суурь үнэ = Тогтмол зардал/ Үйлчилгээний бодит хэмжээ (төг/мянган м3)

Ус ашиглагчийн төлөх төлбөр⁷

Ус ашиглагчийн цэвэр, бохир усны үйлчилгээний сарын нийт төлбөр= Цэвэр усны үйлчилгээний сарын төлбөр+ бохир усны үйлчилгээний сарын төлбөр+суурь үнэ

Цэвэр усны үйлчилгээний сарын төлбөр= Цэвэр усны батлагдсан тариф, төг/м3* сар тутамд ус хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээ, м3

Бохир усны үйлчилгээний сарын төлбөр = Бохир усны батлагдсан тариф, төг/м3*сар тутамд ус ашиглагчийн ашигласан бохир усны хэмжээ, м3

Суурь хураамж, төлбөрийг усны тоолуур суурилуулсан хүйтэн ус дамжуулах хоолойн диаметр эсхүл шугамын диаметр (метр)-ээр тооцоолно.

Хүснэгт 3. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф /нөат-гүй/

№	Тарифын ангилал	Хэмжих нэгж	Онууд				
			2020	2021	2022	2023	2024
Цэвэр усны үйлчилгээний тариф							
1	Үйлдвэр, ААНБ	м3/төг	1380	1380	2070	2690	2690
2	Төсөвт байгууллага	м3/төг	1380	2070	3110	3420	3420
3	Спирт, архи, пиво, ус, ундаа, машин угаалга	м3/төг	1840	1840	2760	3560	3560
4	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	м3/төг	1400	1400	2100	2630	2630
5	Хүн ам-тоолууртай	м3/төг	710	710	1070	1340	1340
6	Хүн ам-тоолуургүй	м3/төг	1040	1040	1560	1950	1950
7	ОСНААУГ ОНӨААТҮГ	м3/төг	535	535	695.5	860	860
8	Чандмань-Налайх ОНӨААТҮГ	м3/төг	345	345	430	430	430
9	ТЗЭ-гч бусад орон сууц	м3/төг	540	540	685	726	858
10	Суурь хураамж-айл өрх	м3/төг	2500	2500	2500	2500	2500

⁷ Монгол Улсын усны эрэлтийн менежмент” усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлангийн 118-119 тал



11	Суурь хураамж-ААНБ	м3/төг	4400-384000	4400-384000	4400-384000	4400-384000	4400-384000
Бохир усны үйлчилгээний тариф							
1	Үйлдвэр, ААНБ	м3/төг	1200	1200	1800	2250	2250
2	Төсөвт байгууллага	м3/төг	1200	1800	2340	2750	2750
3	Спирт, архи, пиво, ус, ундаа, мах, сүү боловсруулах үйлдвэр	м3/төг	1550	1550	2330	2920	2920
4	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, машин угаалга	м3/төг	2050	2050	3070	3850	3850
5	Хүн ам-тоолууртай	м3/төг	580	580	870	1070	1070
6	Хүн ам-тоолуургүй	м3/төг	760	760	1140	1430	1430
7	ОСНААУГ ОНӨААТҮГ	м3/төг	340	340	442	548	548
8	Чандмань-Налайх ОНӨААТҮГ	м3/төг	253	253	355	355	355
9	ТЗЭ-гч бусад орон сууц	м3/төг	320	323	450	500	585
10	Суурь хураамж-айл өрх	м3/төг	500	500	500	500	500
11	Суурь хураамж-ААНБ	м3/төг	1000-76800	1000-76800	1000-76800	1000-76800	1000-76800
Гэр хорооллын хүн амд шугамаар болон зөөврийн ус түгээх үйлчилгээний тариф							
1	Хүн амд УТБ-аас түгээх	м3/төг	909.09	909.09	1818.18	1818.18	1818.18
2	Хүн амд тээврээр түгээх	м3/төг	1636.36	1636.36	2454.55	3681.82	3681.82
3	Зуслан болон алслагдсан цэгээр түгээх	м3/төг	2727.27	2727.27	4090.95	4545.45	4545.45
Ариутгах татуургад зөөврөөр бохир нийлүүлдэг хэрэглэгчдийн бохир ус цэвэрлэгээний тариф							
1	Үйлдвэр ААНБ	м3/төг	850	850	1280	1920	1920
2	Хүн амд	м3/төг	470	470	870	1050	1050
3	УЦБ-ын бохир ус цэвэрлэх тариф	м3/төг	3000	3000	3000	3000	3000

Дээр дурдсан Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг “УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР” ОНӨААТҮГ-ын саналыг үндэслэн Хот Суурины Ус Хангамж, Ариутгах Татуургын Ашиглалт Үйлчилгээг Зохицуулах Хороо баталдаг байна. Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар нь нийслэлийн хүн ам, үйлдвэр, аж ахуйн нэгж газруудыг стандартын шаардлага хангасан унд ахуйн усаар тасралтгүй, найдвартай хангах, гарсан бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үүрэгтэй юм.

Хүснэгт 4. УБ хотын УСУГ-ын 2020-2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт:

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Онууд				
			2020	2021	2022	2023	2024
1	Усны тогтоосон нөөц	сая.м3	94.5	94.5	94.5	94.5	94.5
2	Олборлосон ус	сая.м3	52.8	56.9	57.4	59.0	64.2
3	Татан зайлуулж, цэвэрлэсэн ус	сая.м3	62.8	66.4	64.8	67.8	73.1
4	Орлого болсон нийт цэвэр,	сая.м3	91.5	96.7	97.7	101.4	106.0



	бохир ус						
6	Үйл ажиллагааны нийт орлого	сая.төг	63,223.1	69,765.8	100,978.5	106,337.6	131,504.2
7	Үйл ажиллагааны нийт зардал	сая.төг	84,192.7	84,265.3	98,288.9	116,158.4	128,487.6
8	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	сая.төг	(20,969.6)	(14,499.5)	2,689.6	(9,820.9)	3,016.6
9	Орлогын нэг төгрөгт ногдох зардал	төгрөг	1.3	1.2	1.0	1.1	1.0
10	Дундаж өртөг	төгрөг	920.5	871.4	1,006.0	1,145.5	1,212.1
11	Дундаж тариф	төгрөг	691.2	721.5	1,033.6	1,048.7	1,240.6

Дээр дурдсан УСУГ-ын орлогын 1 төгрөгт ноогдох зардал нь буурсан үзүүлэлттэй буюу үйл ажиллагааны алдагдал нь 2021 онд өмнөх жилээс буурсан, 2022 болон 2024 онд алдагдалгүй ашигтай ажилласан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. УБ хотын УСУГ-ын эдийн засгийн үзүүлэлтийг цэвэр, бохир усны ангиллаар:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Онууд					
			2020	2021	2022	2023	2024	
1	Борлуулсан ус	цэвэр ус	сая.м3	45.5	48.1	48.7	50.6	52.5
		бохир ус	сая.м3	45.9	48.6	49.0	50.8	53.4
2	Үйл ажиллагааны орлого	цэвэр ус	сая.м3	34,669.9	37,537.3	54,814.5	57,580.1	71,261.1
		бохир ус	сая.м3	28,805.6	29,647.9	43,177.8	45,530.4	56,932.4
3	Үйл ажиллагааны зардал	цэвэр ус	сая.төг	59,255.1	58,985.7	73,712.9	77,860.8	86,080.7
		бохир ус	сая.төг	24,937.6	25,279.6	24,576.0	38,297.7	42,406.9
4	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	цэвэр ус	сая.төг	(24,585.2)	(21,448.4)	(18,898.5)	(20,280.6)	(14,819.6)
		бохир ус	сая.төг	3,867.9	4,368.3	18,601.8	7,232.7	14,525.5
5	Дундаж өртөг	цэвэр ус	төгрөг	1,301.4	1,226.1	1,514.3	1,538.8	1,638.6
		бохир ус	төгрөг	542.9	520.2	501.3	753.9	793.7
6	Дундаж тариф	цэвэр ус	төгрөг	761.4	780.3	1,126.1	1,138.0	1,356.5
		бохир ус	төгрөг	627.1	610.1	880.7	896.3	1,065.5

Дээр дурдсан УСУГ-ын 2020-2024 оны цэвэр усны үйл ажиллагааны алдагдал нь буурсан, бохир усны үйл ажиллагаа нь алдагдалгүй тогтмол ашигтай ажилласан сайн талтай байна.

Монгол Улсын 3,5 сая хүн амын 1,76 сая буюу 50 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна. Хүн амыг стандартын шаардлага хангасан унд ахуйн усаар хангах, гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үүргийг УСУГ гүйцэтгэж байна. Энэ байгууллага нь эдийн засгийн хувьд байнгын алдагдалтай ажиллаж ирсэн /хүснэгт 5-ыг харна уу/ бөгөөд сүүлийн жилүүдэд үйл ажиллагааны алдагдал буурах хандлагатай байна.

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь компакт гэрээний үндсэн нөхцөл



болох “Зардал нөхөх төлөвлөгөө”-нд туссаны дагуу цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэх доод хязгаарыг баталсан.

Хүснэгт 6. Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифын доод хязгаар /хувиар/

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
1	Цэвэр ус	26%	18%	23%	15%	3%	4%	22%	2%	2%	2%
2	Бохир ус	25%	25%	23%	30%		2%	25%	2%	2%	2%
3	УТБ-ны тариф	90%						20%			
4	Суурь хураамж	25%						17%			

Зардал нөхөх төлөвлөгөөг 2021-2030 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- 1-р үе шат 2021-2023 он Тарифын орлогоор зардлаа бүрэн нөхөх
- 2-р үе шат 2024-2030 он Тогтвортой байдлыг хангах

Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ, тарифыг дээрх төлөвлөгөөний дагуу нэмэгдүүлж байгаа ч усны суурь хураамжийг 2021 онд 25%-иар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байсан хэдий ч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь “Зардал нөхөх төлөвлөгөө”-ний 1-р үе шатны зорилтын хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан байж болзошгүй юм.

Тогтвортой байдлыг хангахын тулд усны тарифыг ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг нөхөх хэмжээнд тохируулж тогтоох ёстой. Гэтэл Улаанбаатарт үйлчилж буй одоогийн тарифын дагуу цуглуулж байгаа нийт орлого нь ашиглалт, засвар үйлчилгээний зардлаас бага байна. Аймаг, суманд Улаанбаатар хотоос илүү өндөр зардалтай байх боловч орлогын суурь нь бага байх магадлалтай юм.

Тогтвортой тарифаар орлого цуглуулах үйл явцыг үнэлэх, зохицуулах институцийн чадавхыг сайжруулах шаардлагатай байна. Хот суурин газрын төвийн болон захын хорооллын хооронд ус хангамж ба ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний томоохон тэгш бус байдал үүссэн. Өөрөөр хэлбэл, гэр хорооллын оршин суугчдаас авах ус хангамжийн үйлчилгээний тарифыг орон сууцны оршин суугчдаас өндөр тогтоосон байна.

Хүснэгт 7. Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, аймаг, нийслэлээр, төгрөгөөр

	Цэвэр ус				Бохир ус				Суурь хураамж*
	Хүн ам		Үйлдвэр УТБ	Үйлчилгээ, ААНБ /төсөвт/ (дундаж)	Хүн ам		Үйлчилгээ, ААНБ /төсөвт/ (дундаж)	Зөв рөөр	
	Тоолууртай	Тоолуургүй			Тоолууртай	Тоолуургүй			
Архангай	2	2.5	3.35	2.73	1.6	2	3	17	Айл өрх :500
Баян-Өлгий	0.75	0.83	2.6	-	0.75	0.83	2.65	-	



Баянхонгор	1	1.5	5	4	0.6	1	2.55	25	ААНБ :1000- 76800
Булган	2	-	6.5	2.73	2.2	-	6.75	12	
Говьсүмбэр	1.6	-	6.75	3	1.6	-	6	30	
Дархан-Уул	1.97	2.64	3.5	2.73	2.1	2.91	3.75	-	
Дорноговь	2	-	5.25	2.27	-	2	5.25	8	
Дорнод	1.7	2.27	5.21	2.09	1.5	-	4.91	-	
Дундговь	3	4	6.75	5	3	4	6.25	10	
Өвөрхангай	2.4	-	5.9	4	2.3	-	5.7	16.8	
Сүхбаатар	1.8	2	7.6	2.73	1.2	1.5	6.55	80	
Сэлэнгэ	1.5	1.64	4.37	3.64	1.7	1.82	6.25	32.12	
Төв	-	-	4.9	2	-	-	4	-	
Увс	1	1.2	6.75	1.82	1	1.2	7.37	30	
Хөвсгөл	-	-	-	3.64	3.8	4.2	5.8	-	
Хэнтий	2.3	3.3	4.2	3.63	2.5	3.5	4.65	30	
Дундаж	1.78	2.18	5.24	3.06	1.84	2.27	5.09	26.45	
Улаанбаатар	1.34	1.95	3.07	1.81	1.07	1.43	2.94	-	

/ *Бохир усны суурь хураамжийг "төг/сар", бусад нь "төг/л" гэсэн хэмжигдэхүүнээр хэмжинэ/

2021-2025 оны хооронд буюу сүүлийн 5 жилд орон нутагт цэвэр, бохир усны үйлчилгээний тарифт орсон үнийн өөрчлөлт байна.

Хүснэгт 8: Цэвэр, бохир усны үнэ тарифын өөрчлөлт, аймгаар

	Өөрчлөлт орсон тоо	Аймгийн нэр
	1 удаа	Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Төв
	2 удаа	Говьсүмбэр, Дундговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий
	3 удаа	Өвөрхангай, Увс
	4 удаа	Дархан-Уул

Аймгийн төвд мөрдөж байгаа цэвэр усны үйлчилгээний үнэ, тариф

Өрх: Баян-Өлгий аймагт усны үйлчилгээний үнэ хамгийн хямд (тоолууртай: өрхийн 1 литр ус 0.75 төгрөг, тоолуургүй: 1 литр ус 0.83 төгрөг) бол Дундговь аймагт хамгийн өндөр (тоолууртай: 1 литр ус 3 төгрөг, тоолуургүй 1 литр ус 4 төгрөг) байна.

Орон нутагт тоолуурт холбогдсон өрхийн ундны цэвэр усны дундаж үнэ нь 1 литр нь 1.78 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 0.44 төгрөгөөр илүү үнэтэй байна. Тоолуурт холбогдоогүй хүн амын ундны цэвэр усны дундаж үнэ 1 литр нь 2.18 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 0.23 төгрөгөөр илүү үнэтэй байна.

Үйлдвэр, үйлчилгээ, ААНБ:

Хамгийн үнэтэй нь Сүхбаатар аймагт 7.6 төгрөг байгаа бол хамгийн хямд нь Баян-Өлгий аймагт 2.6 төгрөг байна. Харин дундаж үнэ нь 5.24 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 2.17 төгрөгөөр илүү үнэтэй байна.

Ус түгээх байр: Ус түгээх байрнаас ундны цэвэр усаа авч хэрэглэдэг



хэрэглэгчдийн хувьд хамгийн хямд нь Увс аймагт 1 литр усыг 1.82 төгрөгөөр авч байгаа бол хамгийн үнэтэй нь Дундговь аймагт 1 литр усыг 5 төгрөгөөр авч хэрэглэж байна. Харин дундаж үнийн хувьд 3.06 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 1.25 төгрөгөөр илүү үнэтэй байна.

Аймгийн төвд мөрдөж байгаа бохир усны үйлчилгээний үнэ, тариф

Өрх: Бохир усны үйлчилгээний үнэ мөн л Баян-Өлгий аймагт бага (Тоолууртай: 1 литр бохир ус 0.75 төгрөг, тоолуургүй: 1 литр бохир ус 0.83 төгрөг) байна. Харин Хөвсгөл аймагт хамгийн өндөр (тоолууртай: 1 литр бохир ус 3 төгрөг, тоолуургүй: 1 литр бохир ус 4.2 төгрөг) байна.

Орон нутагт тоолуурт холбогдсон хүн амын бохир усны дундаж үнэ нь 1 литр нь 1.84 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 0.77 төгрөгөөр илүү үнэтэй байна. Тоолуурт холбогдоогүй хүн амын бохир усны дундаж үнэ 1 литр нь 2.27 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 0.84 төгрөгөөр илүү үнэтэй байна.

Үйлдвэр, үйлчилгээ, ААНБ:

Хамгийн үнэтэй нь Увс аймагт 7.37 төгрөг байгаа бол хамгийн хямд нь Баянхонгор аймагт 2.55 төгрөг байна. Харин дундаж үнэ нь 5.09 төгрөг байгаа нь Улаанбаатар хотоос 2.15 төгрөгөөр илүү үнэтэй байна.

Зөөврөөр: Ариутгах татуургад зөөврөөр бохир нийлүүлдэг хэрэглэгчдийн бохир ус цэвэрлэгээний тарифын хувьд хамгийн хямд нь Дорноговь аймагт 8 төгрөг, хамгийн үнэтэй нь Сүхбаатар аймагт 80 төгрөг байна.

Суурь хураамж: Орон нутаг болон Улаанбаатар хотод адилхан айл өрхөөс сард 500 төгрөг, аж ахуй нэгж байгууллагаас 1000-76800 төгрөгийн суурь хураамж авч байна. (Аймгийн төвд мөрдөж байгаа цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлтийн талаарх сүүлийн 5 жилийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт хэсэгт оруулсан болно).

Ус бохирдуулсны төлбөр ба эдийн засгийн хөшүүргийн үр нөлөө

Монгол Улсад “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль” батлагдсанаар хаягдал уснаас үүдэлтэй бохирдлыг бууруулах, усны нөөцийг хамгаалах, бохирдлын өртгийг бохирдуулагчид хариуцуулсан эдийн засгийн зохицуулалтын суурь бүрдсэн. Энэхүү төлбөрийн механизм нь “бохирдуулагч төлнө” гэсэн зарчимд тулгуурлан усны хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх, бохирдлыг бууруулах технологи, ус хэмнэх шийдлүүдийг нэвтрүүлэхэд эдийн засгийн дарамт, урамшууллыг зэрэг бий болгох зорилготой.

Хуулийн хэрэгжилтийн үр дүнд ус бохирдуулсны төлбөрийн орлого 2022–2024 онд өссөн нь бодлогын хэрэгжилт сайжирч байгааг харуулж байна. Төлбөрийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр аж ахуйн нэгжүүд бохирдлыг бууруулах, урьдчилан цэвэрлэх, усны хэрэглээг оновчлох арга хэмжээг авч хэрэгжүүлэх сонирхол нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Иймд ус бохирдуулсны төлбөр нь усны чанарын асуудлыг зөвхөн зохицуулалтын бус, **эдийн засгийн хөшүүргээр дамжуулан** байгаль орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэх чухал арга зам болж байгаа бөгөөд цаашид төлбөрийн хувь хэмжээ, суурь тооцооллыг бохирдлын бодит



өртөгтэй уялдуулан уян хатан тогтоох шаардлагатай юм.

ШИГТГЭЭ: Ус бохирдуулсны төлбөр- Австралийн “Polluter pays” зарчмын хэрэгжилт¹

Австрали улс ус бохирдуулалтын асуудалд “бохирдуулагч төлнө” (polluter pays) зарчмыг тууштай баримталж ирсэн. Үйлдвэрлэл, уул уурхай, хот суурин газрын бохир уснаас үүдэлтэй бохирдолд төлбөр ногдуулахдаа бохирдуулах бодисын төрөл, хэмжээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан тооцдог.

Ус бохирдуулсны төлбөрийн тогтолцоо нь бохирдлыг зардал багатай аргаар бууруулах технологи нэвтрүүлэх, бохир усыг дахин ашиглах, цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд чухал нөлөө үзүүлсэн. Үүний үр дүнд усны чанарын доройтол буурах, байгаль орчны хамгаалалтад чиглэсэн хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх бодит үр ашиг гарч байна.

2.4. Усны нөөц ашигласны төлбөр

Ус сувгийн удирдах газар усны нөөц ашигласны төлбөрийг ус ашиглагчдаас цуглуулж, нийслэлийн төсөвт шилжүүлэн төвлөрүүлдэг. Энэ төлбөрийг аж ахуйн нэгж, байгууллага төлөх бөгөөд харин өрхийн унд, ахуйн зориулалтаар ус хэрэглэж буй хэрэглэгчдийг чөлөөлдөг.

Гадаргын болон газрын доорх ус ашигласны төлбөрийг 2012 оноос хойш “Усны нөөц ашигласны төлбөр” гэж нэрлэн, өнгөрсөн жилүүдэд төлбөрийн орлого жил бүр нэмэгдсэн⁸ байна. Байгаль орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг Засгийн газрын тогтоолоор баталдаг.⁹

Усны нөөц ашигласны төлбөр нь сав газар, эдийн засгийн үйл ажиллагаа, усны эх үүсвэр (газар доорх болон гадаргын ус), нөөцийн хэмжээнээс хамааран ялгаатай байна. Газрын доорх ус ашигласны төлбөрийн доод болон дээд хэмжээ нь гадаргын ус ашигласны төлбөрөөс өндөр байдаг. Улсын хэмжээнд хамгийн их ашиглагдаж буй сав газар нь Туул голын сав газар бөгөөд усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ хамгийн өндөр байдаг.

Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд орон сууцны өрхийн усны хэрэглээ бусад өрхийн усны хэрэглээтэй харьцуулахад “маш өндөр, үр ашиггүй” байгааг онцолсон¹⁰ байдаг.

⁸ Монгол Улсын усны эргэлтийн менежмент “Усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн” тайлангийн 50 дугаар тал

⁹ Монгол Улсын усны эрэлтийн менежмент “усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлангийн 50 тал

¹⁰ Монгол Улсын усны эргэлтийн менежмент “Усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн” тайлан



Иймд ус ашиглагч, хэрэглэгчдээс усны үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх, өндөр хэрэглээтэй хэсгээс усны нөөц ашигласны төлбөрийг төлөх асуудлыг судлах нь зүйтэй.

ШИГТГЭЭ. Усны нөөц ашигласны төлбөр- Австралийн туршлага¹

Австралид гүний болон гадаргын ус ашиглалт нь лицензийн тогтолцоонд суурилдаг бөгөөд лицензийн хүрээнд тогтоосон ус ашиглалтын хэмжээнд үндэслэн усны нөөц ашигласны төлбөр ногдуулдаг. Энэхүү төлбөр нь усны нөөцийг үнэгүй, хязгааргүй мэтээр ашиглах хандлагыг бууруулах, улмаар нөөцийн бодит үнэ цэнийг эдийн засгийн хэлбэрээр илэрхийлэх зорилготой.

Усны нөөц ашигласны төлбөрөөс төвлөрсөн орлогыг гүний усны мониторинг, судалгаа, усны төлөвлөлт, экосистем хамгааллын үйл ажиллагаанд зарцуулдаг нь эдийн засгийн хөшүүрэг болон байгаль орчны зорилтыг уялдуулсан сайн жишээ болж байна. Ингэснээр ус ашиглагчид зөвхөн хэрэглэгч бус, харин нөөцийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулагч этгээд болж хувирч байгаа нь онцлог юм.

Усны тухай хуульд ус хэрэглэгч, ус ашиглагчийн хоорондох чухал ялгааг тусгасан. Энэхүү ялгаа нь эдийн засаг, санхүүгийн хэрэглүүрийг ашиглахад үр дүнтэй байдаг. Үүнд:

- Ус хэрэглэгч нь ашиг олон зорилгогүйгээр ус ашигладаг бөгөөд усны үйлчилгээний үнэ төлдөг.
- “Ус хэрэглэгч” гэж ашиг олон зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг хэлнэ.
- Ус хэрэглэгчид усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөгддөг боловч усаа хэрхэн хүлээн авч байгаагаас хамааран усны үйлчилгээний үнэ төлдөг. Ус хэрэглэгчдэд газар тариалан, мал аж ахуйн ус хангамж болон ахуйн ус хэрэглээ хамаарна.
- Ус ашиглагч нь усыг ашиг олон зорилгоор ашигладаг бөгөөд усны нөөц ашигласны төлбөр төлдөг байна.
- “Ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлэх бөгөөд ус ашигласны төлбөр төлдөг.

Усны нөөц ашигласны төлбөрийн орлого 2018 оноос хойш тодорхой хэмжээгээр өссөн бөгөөд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын багахан



хувийг бүрдүүлж байна. 2022 онд ус ашиглагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор 2023 онд уг төлбөрийн орлого өссөн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас олгосон (100 м³/хоног) ус ашиглуулах зөвшөөрлийн тоо 2020 онд 163, 2021 онд 184, 2022 онд 212 байна. 2022 онд зэс, нүүрс, алт олборлолт, ундааны үйлдвэрлэл зэрэг зарим салбарын усны нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлсэн.

Гадаргын ус ашигласны төлбөрийг экологи-эдийн засгийн суурь үнэлгээний 15%-аас 25% болгон нэмэгдүүлсэн. Үүний нэгэн адил газрын доорх ус ашигласны төлбөрийг экологи эдийн засгийн үнэлгээний 20%-аас 35% болгон мөн нэмэгдүүлсэн. Усны нөөц ашигласны төлбөрийн ихэнх хувийг уул уурхай, олборлох үйлдвэрүүд бүрдүүлдэг байна.¹¹

2.5. Ус бохирдуулсны төлбөр

Ус бохирдуулсны төлбөрийг хаягдал ус гаргаж, ус бохирдуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагад ногдуулдаг бөгөөд төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоодог.¹² Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөд “Бохирдуулагч төлнө” гэсэн зарчмыг тусгасан. Үүний дагуу 2021-2023 онд 2 тэрбум хүртэл төгрөгөөр өссөн байна. 2024 оноос хуулийн хэрэгжилт сайжирч, ус бохирдуулсны төлбөр төлсөн иргэж, аж ахуйн нэгжийн тоо, нийт төвлөрүүлсэн төлбөрийн хэмжээ нэмэгдсэн байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу улсын сургууль, эмнэлэг зэрэг улсын төсвөөс санхүүждэг байгууллага хаягдал усны стандартыг мөрдөж, төлбөрөөс чөлөөлөгддөг.

Гэвч байгууллага бүр уг стандартыг хэрэгжүүлэхгүй байна. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ахуйн бохир усыг цэвэрлэх үүрэг хүлээдэг бөгөөд хаягдал усны стандартыг хангахгүй бол ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгддөггүй.

Хаягдал усны тоо хэмжээ, бохирдлын түвшинг тодорхойлох аргачлалын дагуу бохирдуулагч нь хаягдал усыг цэвэрлэж, усан санд хадгалан, дахин боловсруулж, эргүүлэн ашиглаж байгаа тохиолдолд дахин боловсруулсан, эргүүлэн ашигласан хэмжээгээр төлбөрөөс чөлөөлөгдөнө. Усан сангийн хувьд хөрсний нэвчилт болон агаар дахь ууршилтыг бууруулах стандартыг хангасан байх шаардлагатай бөгөөд уг стандартын шаардлагыг хангаагүй тохиолдолд ус бохирдуулсны төлбөр төлнө.

Ус бохирдуулсны төлбөрийн орлогыг орон нутгийн татварын алба Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлнэ. Төлбөрийн орлогыг усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50%-ийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж, цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулдаг.

“Бага болон дунд” хэмжээгээр ус бохирдуулагчдаас ус бохирдуулсны төлбөр тооцон авахын тулд сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах

¹¹ Монгол Улсын усны эрэлтийн менежмент” усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлангийн 51 тал

¹² Монгол Улсын усны эрэлтийн менежмент” усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлангийн 55 тал



зөвшөөрлийг олгох шаардлагатай бөгөөд гол төлөв сав газрын хүчин чадал хангалтгүй тул Усны газар энэхүү үүрэг хариуцлагыг нь орлох боломжгүй байдаг байна. Бага, дунд хэмжээгээр ус бохирдуулагчид бохирдлын ихэнх хувийг үүсгэж байгаа нь анхаарал татаж байгаа юм.

2.6.Бүлгийн дүгнэлт

Дээрх нөхцөл байдлуудыг дүгнэн үзэхэд тарифаар зардал нөхөх боломжгүй хэвээр байна. Дэлхий банкнаас гаргасан Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний олон улсын жишиг (IBNET) тайланд тусгасан Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газрын үйл ажиллагааны зардал нь санхүүгийн ихээхэн эрсдэлийг харуулж байна. Ус сувгийн удирдах газрын хувьд сүүлийн 5 жилийн 3-т нь буюу 2020, 2021, 2023 онуудад үйл ажиллагааны нийт орлого нь тухайн жилийн нийт зардлаас бага буюу алдагдалтай ажилласан байна.

Тарифаас төвлөрүүлж буй орлого хангалтгүй байгаа нь өсөн нэмэгдэж буй эрэлтэд нийцүүлэн бэхжүүлэх шаардлагатай усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын чадвар, чадавхыг хязгаарлаж, улмаар дэд бүтцийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх чадваргүй болоход хүргээд байна. Тухайлбал нийслэл хотын хувьд цэвэр ус дөрвөн том эх үүсвэрээс иргэдийн хэрэглээнд хүрдэг бөгөөд ингэхдээ зөвхөн үйлчилгээний төлбөрийг иргэдээс авдаг. Усыг зохистой хэрэглэх, үнэ цэнтэй болгох эхний алхам бол усны өөрийн үнийг тооцдог болох явдал юм.

Уур амьсгалын өөрчлөлт нь усны нөөцийг багасгаж байдаг. Хэдийгээр энгийн нүдээр харахад ус хаа сайгүй байгаа мэт боловч зохисгүй хэрэглээнээс болж нөөц багассаар байна. Ус гэдэг бол нөхөгддөггүй стратегийн нөөц баялаг юм. Энэ баялгийг хамгаалах нэг арга нь усны үнийг нэмэгдүүлэх замаар зөв зохистой хэрэглээг нийгэмд бий болгох явдал юм.

Австралийн усны үнэ, тариф болон төлбөрийн бодлогын туршлагаас харахад эдийн засгийн зохицуулалтыг усны нөөцийн менежменттэй уялдуулан хэрэгжүүлэх нь усны хомсдолтой нөхцөлд тогтвортой ашиглалтыг хангах чухал механизм болох нь харагдаж байна. Энэхүү туршлага нь Монгол Улсад усны үнэ, тариф, төлбөрийн бодлогыг боловсронгуй болгох, нөөцийн бодит өртгийг илүү оновчтой тусгах шаардлагатайг харуулж байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ: УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

Монгол орны усны нийт нөөц олон жилийн дунджаар 564.8 сая.м³ бөгөөд үүний 34.6 сая.м³ нь гол, мөрөн, 500.0 сая.м³ нь нуур, 19.4 сая.м³ нь мөнх цас, мөсөн гол, 10.8 сая.м³ нь газрын доорх ус байна. Гол мөрний нийт урсцын горим 1972 онд 34.6 км³ /жил байсан бол 2021 онд 52.3 км³/с, 2022 онд жилийн дундаж урсац 36.7 км³/с байсан нь олон жилийн дунджаас 3.8 км³/с-ээр илүү урсацтай жил байв.

Монгол орны усны нөөц жигд бус тархацтай бөгөөд усны нийт нөөцийн 78% нь нутгийн хойд болон баруун хэсэгт буюу цэнгэг устай хамгийн том нуур, гол мөрөн бүхий бүс нутагт байрладаг онцлогтой. Нутгийн хойд хэсэгт жилийн дундаж хур тунадас 400 мм-ээс давсан үзүүлэлттэй байхад говийн бүсэд 40 мм байдаг. Жилийн нийт хур тунадасны 85% нь 4-9 дүгээр сард ордог байна. Ихэнх нөөцийг гол мөрөн (6%), нуур (89%), мөсөн гол (3%) тус тус бүрдүүлдэг. Хатуу ширүүн өвлийн улиралд агаарын температур цельсийн -28°C-40°C хооронд хэлбэлздэг тул ихэнх гадаргын ус хөлдөж, хавар гэсэх хүртэл ашиглах боломжгүй байдал үүсдэг байна.

3.1 Гадаргын усны нөөцийн өнөөгийн байдал

Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 5 100 гаруй гол мөрөн, 3700 гаруй нуур, 260 мөсөн гол байна. Цаг уурын өөрчлөлт дулаарлын хэмжээ дунджаар 2-3 хэмээр нэмэгдсэн, гангийн давтамж, хуурайшилтын явц хурдацтай явагдаж байгаагаас 2016 оны усны тооллогын дүнгээр улсын хэмжээнд нийт 2245 нуур тойром тоологдсоноос 16.7% нь буюу 376 нь ширгэсэн байна.

Sentinal-2 дагуулын 2022 оны мэдээгээр нийт 3718 нуур, тэдгээрийн нийт талбай 14305.6 км² байна. Үүнийг 1:100000-ны байр зүйн зураг буюу 1945 оны мэдээтэй харьцуулахад нийт 569 нуур тойром ширгэсэн ба талбайн хэмжээ 1158.6 км² буюу 7.4%-иар буурсан байна. Харин өмнөх 2021 оны хиймэл дагуулын мэдээний үр дүнтэй харьцуулахад нийт талбай 43.5 км² буюу 0.3%-иар нэмэгдсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн Монгол орны өндөр температурын улмаас мөсөн голын хэмжээ багасаж, голын урсацад нөлөөлөх болно. Нутгийн баруун хэсгийн мөсөн голуудаас болон Хөвсгөл нуур зэрэг мөнх цэвдэг бүхий ойт хээрийн бүсээс эх авдаг гол мөрөн, нуурын усны түвшин, урсцын хэмжээ нэмэгдэх төлөвтэй. Мөсөн голын талбайн хэмжээ 1940-өөд оноос хойш 1990 онд 12.1%, 2000 онд 15.7%, 2019 онд 36.8%-иар тус тус багассан нь өнгөрсөн 70 жилийн хугацаанд нийт 37%-иар буурсан болохыг харуулж байна.

Үүний шалтгааныг дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй холбон тайлбарлаж байгаа бөгөөд нийт хамрах хэмжээ болон цэвдэг, мөсөн голын мөсний зузаан нь багассан байна.

Манай орны гол мөрний нийт урсац 2021 онд 52.3 км³/с буюу сүүлийн 25 орчим жилд тохиолдсон хамгийн их урсацтай жил, 2022 онд жилийн дундаж урсац 36.7 км³/с буюу 22.9 хувийн хангамжтай болсон нь өмнөх оноос 15.7 км³/с-ээр буурав. Гэвч олон жилийн дунджаас 3.8 км³ /с-ээр илүү урсацтай жил болов.



Туул гол нь Улаанбаатар хот орчимд 2019-2023 онд хавартаа байнга устай байсан ба ялангуяа голдирлын харгиатай хэсэгт эрт мөсгүй болох үзэгдэл сүүлийн жилүүдэд олонтоо тохиох болсон. Энэ нь ул хөрсний усыг байнга тэжээдэг болсон антропоген хүчин зүйлийн нөлөөгөөр, намар, голын ус харьцангуй гүехэн байж, нимгэн мөсөн бүрхүүл тогтох, голын мөс хотын тоос, тортгоор харлаж, эрт хайлдаг болсонтой холбоотой.

3.2 Газар доорх усны нөөцийн өнөөгийн байдал

Манай орны хэмжээнд газрын доорх усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь байгалийн бүс, бүслүүр, ус агуулах чулуулгийн тогтоц найрлагаас хамаарч өөр өөр байна. Улсын нийт газар нутагт бүрэлдэн бий болж байгаа усны нөөцийн 2%-ийг газрын доорх ус эзэлдэг бөгөөд ус хэрэглээнийхээ 80 гаруй хувийг газрын доорх усаар хангаж байна.

Газрын доорх ус нь усны эргэлтийн нэг хэсэг бөгөөд цаг агаарын байдлаас ихээхэн хамаардаг. Сүүлийн үеийн судалгаануудын дүнгээс харахад цаг уурын дулаарал, хуурайшилт, цөлжилтийн шинж монгол орны нутаг дэвсгэрт эрчимжих хандлага бий болж, гол нуур, тойрмын усны гадаргын ууршилт нэмэгдэн усны баланст нөлөөлж, мөстлийн хайлалт тэлж байна.

Жилийн дундаж агаарын температурын 1940-2023 оны өөрчлөлтийг орон зайн тархалтаар авч үзвэл нийт нутгаар дулааралт 2°-3°C-ын хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд хамгийн их дулааралт Улаанбаатар хот, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Сэлэнгэ аймгийн Баруунхараа сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумд орчмоор ажиглагдаж 3.3-3.5°C-д хүрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1987-1995 он хүртэлх хугацаанд газрын доорх усны нөөц тогтоох хайгуул судалгааны ажил жилдээ 5-18 хүртэлх ордод хийгддэг байсан бол 2000-2002 онд нэг ч ордод хийгдээгүй, 2003 оноос жил бүр хийгдэж байсан ч тоо нь цөөрсөн байна. Харин аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн хөрөнгөөр газрын доорх усны хайгуул, судалгааны ажлыг 2003-2023 онд 107 талбайд хийж, нийт 12,321.38 л/с нөөцийг Усны нөөцийн зөвлөлөөр батлуулсан байна.

Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг байгуулан ажиллаж байна. Монгол орны хэмжээнд унд, ахуйн болон уул уурхай, үйлдвэрлэлд ашиглагдах усны эх үүсвэрийн газрын доорх усны ордын талбайд усны горимын хяналт-шинжилгээг 1974 оноос хийж эхэлсэн.

3.3 Усны нөөцийн ашиглалт

Манай орны нийт ус ашиглалт, хэрэглээ жилдээ 500 сая.м³ орчим байгаа ба хүн амын өсөлт, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдан жилээс жилд нэмэгдэж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан Байгаль орчин-эдийн засгийн дансны нэг бүрэлдэхүүн болох Усны биет урсгалын дансны 2023 оны туршилт тооцоогоор улсын хэмжээнд нийт 2140.1 сая м³ усыг байгаль орчноос олборлосны



1689.1 (78.9%) сая м³ усыг гадаргын уснаас, 450.9 (21.1%) сая м³ усыг газрын доорх усны нөөцөөс олборлосон байна. Усны нийт олборлолт нь Усны газрын “Ус ашиглалтын баланс”-д усан цахилгаан станцын хоолойгоор дамжуулан эрчим хүч үйлдвэрлэхэд ашигласан усыг олборлосон усны хэмжээнд тооцож оруулдаггүйтэй холбоотойгоор усны нийт олборлолтын хэмжээ зөрүүтэй байна. Ус ашиглалтын балансаар 2021 онд нийт 594.8 сая.м³/ жил, 2022 онд 606.2 сая.м³ /жил, 2023 онд 679.1 сая.м³ /жил ус олборлож, ашигласан байна.

Хүснэгт 9. Усны нийт олборлолт, усны нөөцийн төрлөөр, 2023 он

Салбар	Газар доорх ус	Гадаргын ус	Нийт	Дүнд эзлэх хувь
	сая м ³			хувь
Хөдөө аж ахуй	110.9	226.1	337.5	15.0
Уул уурхай, олборлох	171.1	226.6	171.1	7.6
Боловсруулах үйлдвэрлэл	6.0	-	6.0	0.3
Барилга	3.3	-	3.3	0.1
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	21.2	1 462.5	1483.7	66.1
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	78.5	-	78.5	3.5
Бусад	13.6	-	13.6	0.6
Өрх	46.3	-	46.3	2.1
Нийт	450.9	1 689.1	2 140.1	100

Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлийн салбарт олборлосон 1483.7 сая м³ усны 1462.5 сая м³ ус нь усан цахилгаан станцад гадаргын уснаас олборлосон бол хөдөө аж ахуйн салбарт олборлосон 337.5 сая м³ усны 110.9 сая м³ усыг газар доорх усны эх үүсвэрээс олборложээ.

Хүснэгт 10. Усны нийт олборлолт, зориулалтаар

Зориулалт	2020	2021	2022	2023	2023/2022
	сая м ³				хувь
Усан цахилгаан станц	2 218.9	2313.1	1627.1	1462.5	-10.1
Усжуулалтын ус	352.9	339.1	338.6	337.5	-0.3
Уурхайн ус	92.8	109.9	89.4	171.1	91.3
Хөргөлтийн ус	40.7	41.3	46.0	21.2	-54.0
Бусад	18.9	16.1	58.7	59.7	1.6
Унд, ахуйд хэрэглэх ус	85.8	88.4	84.6	88.0	4.0
Нийт	2 809.9	2 907.9	2 244.5	2 140.1	-4.7

Усны нийт олборлолтыг зориулалтаар нь авч үзвэл 2023 онд хамгийн их буюу 1462.5 (68.3%) сая м³ усыг усан цахилгаан станцад, 337.5 (15.8%) сая м³ усыг хөдөө аж ахуйн усжуулалтад, 171.1 (8.0%) сая м³ усыг уурхайд, 88.0 (4.1%) сая м³ усыг унд, ахуйн хэрэглээнд ашиглажээ.

Хэт төвлөрлөөс үүдэлтэй экологийн доройтол, голуудын усны нөөцийн хомсдол, бохирдлын асуудалд анхаарч ус хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн технологийн шинэчлэл хийх, үнэ тарифын бодлогыг оновчлох, ус



ашиглагч, хэрэглэгчдийн хэрэглээний сэтгэлгээг өөрчлөх талаар бодлогын түвшинд дорвитой алхмуудыг хийх шаардлагатай байна.

Ундны усны зэрэглэлтэй маш цэвэр усыг Туул голын аллювийн хурдсаас татан авч Улаанбаатар хотын төвлөрсөн сүлжээгээр дамжуулан бүх төрлийн зориулалтаар ашиглаж нөөц хүрэлцэхгүй гэхтэй зэрэгцэн, шинэ эх үүсвэрийн хайгуул хийхээс илүүтэй, усыг зохистой ашиглах; хэмнэх, дахин ашиглах ажил хийгдэхгүй байна.

Аливаа гол мөрний усны нөөцөөс авч ашиглаж болох усны хэмжээ дунджаар 10 хувь байдаг. Одоогоор Туул голын урсцын 10 орчим, зарим тохиолдолд 12 хувийг нь хэрэглэж байна. Энэ хэмжээ 20 хувь хүрвэл хэрэглээг¹³ хязгаарлахаас өөр аргагүй.

3.4 Олон улсын хандлага

Олон улсын туршлага - Эрсдэлд суурилсан хандлагатай гүний усны менежмент ба хэрэглээ¹⁴

Сайн засаглал нь Австрали улсын гүний усны нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглах, мөн усны салбар дахь хөрөнгө оруулалтын итгэлцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Усны нөөцийн үр ашигтай төлөвлөлт нь зөвхөн эрсдэлд суурилсан хандлагыг хэрэгжүүлэхэд чиглэх бус, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны ашиг сонирхлын тэнцвэрийг хангах цогц зорилгыг агуулдаг.

Арга хэмжээ:

Шинэлэг, үр дүнтэй гүний усны менежментийг төлөвлөхийн тулд гүний усны нөөцийг эрсдэлд суурилсан ангиллын аргачлалаар үнэлэх шаардлагатай. Энэхүү үнэлгээ нь гүний усны нөөцийн бодит нөхцөл байдал, тодорхой бус хүчин зүйлсийг системтэйгээр харгалзан үзэж, шаардлагатай тохиолдолд үндэсний болон мужийн түвшний усны менежментийн бодлого, шийдвэр гаргалтад нотолгоонд суурилсан мэдээлэл өгөхөд чиглэдэг.

Гүний усны нөөцтэй холбоотой эрсдэл нь дараах тодорхой бус байдалтай шууд хамааралтай байна. Үүнд:

- гүний усны нөөцийн хэмжээ болон нөхөн сэлбэгдэх хурд;
- усны чанарын өөрчлөлт, доройтол;
- ойр орчмын ус хэрэглэгчид болон уснаас хамааралтай экосистемд үзүүлэх

¹³ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБХХ, Тогтвортой хөгжлийн зорилго 6:Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах нь, 2019

¹⁴ OECD (2015). Water Resources Allocation: Sharing Risks and Opportunities.



нөлөө.

Үүнээс гадна гүний усны олборлолт нь гадаргын усны нөөц, гүний болон гадаргын усны чанар, тэдгээрээс хамааралтай экосистемд үзүүлэх нөлөөллөөрөө дамжин нийлмэл эрсдэл үүсгэдэг. Иймд гүний болон гадаргын усны харилцан хамаарлыг үнэлэх, удирдах үйл явцад эрсдэлд суурилсан хандлагыг системтэйгээр нэвтрүүлэх нь зайлшгүй шаардлагатай.

Энэхүү хандлагыг бодитой хэрэгжүүлэхийн тулд гүний усны менежментэд үр ашигтай, үр дүнтэй, ил тод зохицуулалтын процесс-ийг бүрдүүлэх нь чухал бөгөөд энэ нь усны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах үндсэн нөхцөл болдог.

Зохицуулалтын орчин ба усны худалдаа¹⁵:

Австрал улсын усны төлөвлөлт, менежментийн бодлогын удирдамжид уул уурхай болон бусад олборлох үйлдвэрлэл, тэр дундаа эрчим хүч үйлдвэрлэлд ашиглагдах усны хэрэглээг усны нийт төсөвт заавал тусгах, тухайн усны төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх, эсхүл түүнтэй нийцсэн зохицуулалтаар удирдах шаардлагатайг тодорхой заасан байна. Энэхүү зохицуулалт нь усны нөөцөд үзүүлэх хуримтлагдсан нөлөөллийг үнэлэх, салбар хоорондын ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, улмаар усны нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглахад чиглэдэг. Уг бодлогын хүрээнд дараах үндсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг. Үүнд:

- Гүний усны худалдааны дүрэм, гүний болон гадаргын усны худалдааны зохистой ашиглалтын боломж, тэдгээрийн байгаль орчин, эдийн засагт үзүүлэх үр нөлөөнд үнэлгээ хийх;
- Гүний усны худалдаа, дахин боловсруулсан усны хэрэглээ зэрэг шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлэхэд саад болж буй зохицуулалтын орчин, хууль эрх зүйн тодорхой бус байдлыг тодорхойлон, үе шаттайгаар шийдвэрлэх;
- Уул уурхай, эрчим хүч зэрэг салбарын гүний усны олборлолт, ашиглалтад үр дүнд суурилсан зохицуулалт, бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх.

Ирээдүйд чиглэсэн төлөвлөлт ба удирдлага- Усны нэгдсэн эргэлтэд гүний усны боломж:¹⁶

Австралид янз бүрийн чанартай гүний усны асар их нөөц байдаг бөгөөд энэ нь тус улсын ихэнх бүс нутагт найдвартай, хэмнэлттэй усны цорын ганц эх үүсвэр болж байна. Одоогийн байдлаар гүний ус нь аж үйлдвэр, хөдөө аж ахуй, ахуйн болон хотын усан хангамжийг дэмжих үндсэн эх үүсвэр байхаас гадна ирээдүйн усны хэрэгцээг хангах стратегийн нөөц болохыг бодлого боловсруулагчид улам бүр хүлээн зөвшөөрч байна.

¹⁵ Intergovernmental Agreement on a National Water Initiative (NWI). Canberra.

¹⁶ Australian Government (2016). *National Water Quality Management Strategy*.



3.5 Бүлгийн дүгнэлт

Усны нөөц, түүний бүрэлдэх зүй тогтол, нөхөн сэргэх чадамж, газарзүйн тогтоц, онцлогийг харгалзсан төлбөрийн тогтолцоог судалгаа, үндэслэлтэй хөшүүрэг болохуйц хэмжээгээр тогтоож хэрэгжүүлэх хэрэгтэй байна

Газрын доорх гүний усны нөөц удаан сэргэдэг, ялангуяа говийн бүсийн газрын доорх цэнгэг усны нөөцийг ашиглахдаа оршин суугчдын ус хангамжийн асуудлыг тэргүүн ээлжид тавьж нөөцийн боломжит хэмжээнд нарийн судалгаа хийсний үндсэн дээр үйлдвэрлэлийн зориулалтаар маш хэмнэлттэй ашиглуулах зарчмыг бодлогын хэмжээнд авч үзэх шаардлагатай байна.

Бид усыг дуусашгүй ундарсаар байх мэтээр хүлээн авах боломжгүй бөгөөд ялангуяа манай орны усны нөөцийн бүрдэл, хуваарилалт маш өвөрмөц онцлогтойг анхаарч иргэн, үйлдвэр аж ахуйн нэгж, төр засгийн байгууллага усны асуудлыг бүрэн дүүрэн ойлгож, үнэлж дүгнэн оновчтой менежмент хийх шаардлагатай тулгараад байна. Ийм учраас усыг хамгаалах, ашиглахдаа шинэ арга барилаар харьцах буюу хандлагаа өөрчлөх цаг нь болжээ.

Австрали улсын туршлагаас харахад гүний усны тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд зөвхөн техникийн шийдлүүд хангалтгүй бөгөөд хүний нөөц, институцийн чадавх шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Судалгаа, боловсрол, сургалтын уялдаа хангагдаагүй нөхцөлд гүний усны менежментийн бодлого, зохицуулалтын хэрэгжилт сулрах эрсдэлтэй.

Иймээс салбарын мэргэжлийн сүлжээ, засгийн газрын байгууллага, судалгааны институт, хувийн хэвшлийн хоорондын тогтвортой хамтын ажиллагаа нь мэдлэг, туршлага дамжуулах, инновацыг нэвтрүүлэх гол суурь болж байна. Усны менежментийн сургалтын тогтолцоонд гүний усны асуудлыг системтэйгээр нэгтгэх нь бодлого боловсруулах, мониторинг хийх, эрсдэлийг үнэлэх чадамжтай мэргэжилтэн бэлтгэх үндсэн нөхцөл болдог.

Түүнчлэн ажиллах хүчний дунд болон урт хугацааны хэрэгцээг урьдчилан үнэлж, ирэх арван жилд уур амьсгалын өөрчлөлт, усны нөөцийн дарамтыг даван туулах чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх нь салбарын тогтвортой хөгжлийг хангах стратегийн ач холбогдолтой. Эцэст нь, Засгийн газар, судалгаа шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь гүний усны менежментийн мэдлэгт суурилсан шийдвэр гаргалт, бодлого-хэрэгжилтийн уялдааг сайжруулж, гүний усны нөөцийг урт хугацаанд хамгаалах, зохистой ашиглах чадавхыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.



НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсын усны салбарын эрх зүйн орчин бүрдэж, үндэсний хөгжлийн бодлогын баримт бичигт туссан боловч хэрэгжилтийн түвшинд тодорхой хүндрэл, сул талууд ажиглагдаж байна. Усны нөөцийг стратегийн ач холбогдол бүхий нийтийн өмч, үнэт баялаг гэж хуульчилсан нь салбарын бодлогын суурь нөхцөлийг бүрдүүлсэн хэдий ч байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо, институцийн чадавх, санхүүжилтийн тогтвортой байдал хангалтгүй байна.

Усны салбарын бүтэц, чиг үүргийн хувьд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт-шинжилгээ хийх болон үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүтэц, тогтолцоо бүрдсэн.

Одоогийн мөрдөж буй усны үнэ тариф нь усны нөөцийн бодит өртөг, нөхөн сэргээлт, хамгаалалтын зардлыг бүрэн тусгаагүй, зөвхөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны зардалд суурилсан байгаа нь усны нөөцийг эдийн засгийн үнэлэмжтэй нөөц гэж үзэх зарчимтай нийцэхгүй байна. Үүний улмаас дараах хүндрэлүүд тулгарч байна. Үүнд:

- Усны хэрэглээнд хэмнэлт, хариуцлагын механизм сул;
- Усны салбарын байгууллагууд алдагдалтай ажилладаг;
- Нөөцийг хамгаалах, дахин ашиглах, шинэ эх үүсвэр бий болгох хөрөнгө оруулалтын эх үүсвэр хомс байна.

Усны үнэ тарифын бодлогыг шинэчлэх, усны нөөцийн менежментийг шинжлэх ухаанч, эдийн засгийн үндэслэлтэйгээр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Усны үйлчилгээ үзүүлэгчийн үр ашгийг дээшлүүлэх, түүн дотор олон нийтэд суурилсан менежментийн систем зэрэг шинэ арга барил нэвтрүүлэх шаардлагатай байна. Олон улсын туршлагаас харахад усны үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгө оруулалтыг орлоготой тэнцвэржүүлж, ашиг олох зарчмыг нэвтрүүлбэл хамгийн сайн ажилладаг.

Монгол Улсын усны хэрэглээний 80 гаруй хувь нь газрын доорх уснаас хамаарч байгаа нь урт хугацааны эрсдэлийг нэмэгдүүлж байна. Гүний ус нь нөхөн сэргэх хугацаа урт, байгаль экологийн хувьд эмзэг тул ялангуяа говийн бүсийн усны нөөцөд тулгуурласан уул уурхай, үйлдвэрлэлийн ашиглалт нь хязгаарлалт, нарийн зохицуулалт шаардаж байна. Усны хайгуул, нөөц тогтоох судалгаа хангалтгүй, ашиглагдаагүй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогын зохицуулалт сул хэвээр байна. Усны нөөцийг хамгаалах, хэмнэлттэй ашиглах, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, байгууллагын уялдаа холбоо, санхүүжилт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх нь усны салбарын тогтвортой хөгжлийг хангах үндсэн нөхцөл болох юм.



САНАЛ

БҮЛГИЙН НЭР	АСУУДАЛ	САЙЖРУУЛАХ САНАЛ
Усны салбарын тогтолцоо	<ul style="list-style-type: none"> - Сав газрын талуудын оролцооны зөвлөл нь оролцогч талуудын оролцоог хангах, шийдвэр гаргах, хяналт-шинжилгээг явуулах, сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг хянах үүрэг, хариуцлага хүлээдэг, янз бүрийн оролцогч талын бүлгийн төлөөлөл хамаардаг. Энэхүү оролцогч талуудад санхүүгийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан үйл ажиллагаагаа тогтвортой явуулж чаддаггүй. 	<ul style="list-style-type: none"> - БОАЖС-ын 2018 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан “Сав газрын талуудын оролцооны, ажиллах журам”-д заасны дагуу зөвлөлийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж үйл ажиллагааг тогтмолжуулах. Ингэснээр олон нийтийн хяналт, ААНБ болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, уялдаа холбоо сайжирна; - Сав газрын менежментийг бодит үр дүнд хүргэх.
Усны үнэ тариф, өнөөгийн нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> - Дэлхийн бусад улс, орнуудад усны үнэ, тарифын хувьд усны үнэ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны зардлын нийлбэрээр иргэд, ААНБ-д нийлүүлэгддэг. Харин манай улсын хувьд усны өөрийн үнэ огт байхгүй бөгөөд зөвхөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны зардлын үнээр иргэд, ААНБ-д хүрдэг. Мөн сүүлийн жилүүдэд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь үйл ажиллагааныхаа зардлыг ч бүрэн нөхөж ажиллаж чадахгүй байгаагаас үүдэн усны салбар алдагдалтай ажиллах болсон. 	<ul style="list-style-type: none"> - Усны “өөрийн үнэ”-ийг тогтоож, тарифын тогтолцоонд нөөцийн бодит өртөг, нөхөн сэргээлтийн зардлыг тусгах. Ингэснээр усны зүй зохистой хэрэглээ бий болно; - Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийн 6.3.2-т “Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өсгөх зарчимд суурилж тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны зардлыг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбогдуулан шинэчилдэг байх. Ингэснээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг алдагдалтай ажиллаж байгаа нөхцөл байдлаас гаргах боломж



		бүрдэнэ.
Усны нөөц, ус ашиглалтын байдал	<ul style="list-style-type: none">- Улсын хэмжээнд усны нөөцийн 2 хүртэлх хувийг бүрдүүлдэг газрын доорх усны нөөцөөс ус хэрэглээнийхээ 80 гаруй хувийг хангаж байна. Газрын доорх усны нөөц нь гадаргын ус болон цаг агаарын байдлаас ихээхэн хамааралтай байдгаас уур амьсгалын өөрчлөлт, хүн амын хотжилт, төвлөрлөөс шалтгаалан газар доорх усны нөөцөд нөлөөлөх эрсдэлтэй байна;- Хүн амын унд, ахуйн болон уул уурхай, үйлдвэрлэлд газрын доорх усыг түлхүү хэрэглэж байна.	<ul style="list-style-type: none">- Газрын доорх усны нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр жилд дунджаар 3 ус хангамжийн эх үүсвэрт хийхээр төлөвлөлтөд тусгаж байх;- Усны нэгдсэн бодлого тодорхойлох түвшинд эхний ээлжид аймгийн төв, хот суурины хүн амыг усны найдвартай эх үүсвэрээр хангах;- Газрын доорх усны нөөц нь тогтоогдсон боловч 25 жилийн турш ашиглаагүй ордын усны нөөцийг дахин үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиглах механизмыг бүрдүүлэх.- Гадаргын ус, гүний ус болон бусад усны эх үүсвэрийг нэгдсэн байдлаар удирдах замаар хот, хөдөөгийн усан хангамжийн системийн уялдааг хангах;- Цэвэршүүлсэн борооны ус, дахин боловсруулсан бохир ус, уст давхаргыг дахин цэнэглэх (aquifer recharge), цэвэршүүлсэн шорвог буюу давсархаг гүний ус зэрэг шинэлэг усны эх үүсвэрийг идэвхтэй ашиглах;- Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн нөлөөг харгалзан гүний болон гадаргын усны олборлолтын дээд хязгаарыг үнэлэх, бүс нутгийн онцлогт нийцсэн протокол боловсруулах;- Усны системийн загварчлалыг сайжруулах зорилгоор усны тоо хэмжээ, чанарын мэдээллийн уялдаа холбоо, чанар, хүртээмжийг дээшлүүлэх;- Газрын доорх усны хэрэглээг бүс нутгийн онцлогт тулгуурлан хатуу зохицуулах.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээр:

- Монгол улсын усны нөөцийн тогтолцоо ба менежментийн тойм, усны аюулгүй байдлын үнэлгээ, 2025 оны 7-р сар, Азийн хөгжлийн банк
- Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2021-2023 он, 2025 он, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
- Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах нь, усны нөөцийн менежментийн төлөвлөгөө, бодлогын уялдаа, ТХЗ 6-ын шалгуур үзүүлэлтүүд, тодорхойлох аргачлал, хөгжлийн төлөвлөлт, 2019, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБХХ
- Байгаль орчин-эдийн засгийн дансны систем-Усны биет урсгалын данс, 2023, Үндэсний статистикийн хороо
- Усны үнэ тариф, төлбөрийг тооцох гарын авлага УБ хот. 2012 он
- “Монгол Улсын усны эрэлтийн менежмент” усны салбарын үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн гол үр дүн тайлан.
- Хэрэглэгчийн цэвэр, бохир усны 2021-2024 оны хооронд батлагдсан тарифын мэдээлэл, үйлчилгээний тариф

Англи хэл дээр:

- Australian Framework, National Groundwater Strategic Framework 2016–2026
- Harrington N and Cook P, 2014, Groundwater in Australia, National Centre for Groundwater Research and Training, Australia.